“ПРЕМИУМКӨҮЛ КОРПОРАЦИ” ХХК

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших “Төхөм нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Улаанбаатар хот
2026 он

Агуулга

1. Төслийн товч танилцуулга 1

1.1. Төслийн байршил 1

1.2. Ордын нөөц 2

1.3. Техник эдийн засгийн үндэслэл 3

1.4. Үйл ажиллагааны технологи 3

1.5. Хүчин чадал 4

1.6. Ажиллах хүчин 4

1.7. Дэд бүтэц 4

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга 6

2.1. Байгаль орчны төлөв байдал 6

3. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө 10

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ 10

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 11

3.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлт, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө 13

3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 14

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 14

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө 14

3.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 15

3.7. Хог хаягдлын менежмент 15

3.8. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 16

3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 17

3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө 18

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн солбицол 2
Хүснэгт 1. Ордын нөөц 3
Хүснэгт 2. Барилга байгууламж 4
Хүснэгт 3. Хөрсний зүсэлт 8
Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 11
Хүснэгт 5. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээниий төлөвлөгөө 12
Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 12
Хүснэгт 7. Нөхөн сэргээлт, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ 13
Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 14
Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 15
Хүснэгт 10. Хог хаядлын менежментийн төлөвлөгөө 15
Хүснэгт 11. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 16
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 17
Хүснэгт 13. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал 18
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн 18

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил 2
Зураг 2. Уурхайн барилга байгууламж 4
Зураг 3. Төслийн талбайн налуугийн зураглал 6
Зураг 4. Төслийн талбайн өндөршлийн зураглал 7
Зураг 5. Төслийн талбайн хөрсний хэв шинж 8

1. Төслийн товч танилцуулга

Төслийн нэр	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших MV-016975 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж, байгууллагын нэр	“Премиумкөүл корпораци” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011359044 Регистрийн дугаар: 5615631
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Жаргалант, 60-63 тоот Утас: 976-99091802, 91000627
Төслийн товч тодорхойлолт	ЭБМЗ-ийн 2011 оны 4-р сарын 6-ий өдрийн ХХ-06-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2011 оны 5-р сарын 2-ны өдрийн 162 тоот тушаалаар ордын нөөцийг баталсан. • Төхөмийн хүрэн нүүрсний ордын талбайд баттай (А) нөөцийг 2800332.4 тн-оор, бодитой (В) нөөцийг 3831947.5 тн-оор, боломжтой (С) нөөцийг 1642173.1 тн-оор, нийт баттай бодитой болон боломжтой (А+В+С) нөөцийг 8274453.0 тн-оор, цэвэр нүүрсний баттай (А) нөөцийг 65848345.4 тн оор, бодитой (В) нөөцийг 72265591.2 тн-оор, боломжтой (С) нөөцийг 52299428.5 тн-оор, нийт баттай бодитой боломжтой (А+В+С) нөөцийг 190413365.4 тн-оор, уулын цултай нүүрсний баттай (А) нөөцийг 69010130.5 тн-оор, бодитой (В) нөөцийг 75930632.0 тн-оор, боломжтой (С) нөөцийг 54983742.8 тн-оор, нийт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) нөөцийг 199924505.3 тн-оор хүлээн авсан. • 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Төхөмийн ордод баттай болон бодиттой (А+В) зэргээр 264,877.93 мян.тн, боломжтой (С) зэргээр 54,983,60 мян.тн, нийт 199,002.64 мян.тн цэвэр нүүрсний үлдэгдэл нөөцтэй байна АМГТГ-ийн даргын 2024 оны 6-р сарын 24-ны өдрийн т/87 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2024 оны 5-р сарын 8-ны өдрийн т/24-14-06 тоот дүгнэлт батлагдсан. Төслийн нийт хугацаанд 37,802.8 мян.м3 хөрс хуулж, нийт 141,958.0 мян.м^3 уулын цулын ажил гүйцэтгэж, 3.0 сая.тн/жилийн хүчин чадалтайгаар 46 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.


1.1. Төслийн байршил

Ашиглалт явуулах тусгай зөвшөөрлийн талбай нь газарзүйн байршлаар Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос 640 км, Сүхбаатар сумын төвөөс зүүн урагш 36 км, Баруун Урт хотоос зүүн урагш 80-км-т, Сүхбаатар-Дорнод аймгуудыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас 20 км зайд оршино .

Төхөмийн талбай нь тал хээрийн бүс дахь бөмбөгөр оройтой намхан уул, тэгшивтэр тал бүхий бүсэд хамаарна. Талбайн үнэлэхүй өндөр 850-950 м-ийн хооронд хэлбэлзэх ба хамгийн өндөр уул нь талбайн урд хэсэгт орших Цагаан өндөр (1047.0 м), хамгийн намхан цэг нь талбайн зүүн хэсэг дэх Холбоогийн говь (840 м) бөгөөд талбайн ихэнх хэсгийг (70%) тал, хөндий эзэлнэ.

- Талбайн хэмжээ: 537.95 гектар

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-50–49



Зураг 1. Төслийн байршил

Хүснэгт 1. Талбайн солбицол

№	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	114	15	0.02	46	33	51.76
2	114	13	22.39	46	33	51.76
3	114	13	22.39	46	35	1.76
4	114	15	32.4	46	35	1.76
5	114	15	32.4	46	34	20.22
6	114	15	0.02	46	34	20.22

1.2. Ордын нөөц

ЭБМЗ-ийн 2011 оны 4-р сарын 6-ий өдрийн ХХ-06-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2011 оны 5-р сарын 2-ы өдрийн 162 тоот тушаалаар “Төхөм”-ийн хүрэн нүүрсний ордын талбайд баттай (А) нөөцийг 2,800,332.4 тн-оор, бодитой (В) нөөцийг 3,831,947.5 тн-оор, боломжтой (С) нөөцийг 1,642,173.1 тн-оор, нийт баттай бодитой болон боломжтой (А+В+С) нөөцийг 8,274,453.0 тн-оор, цэвэр нүүрсний баттай (А) нөөцийг 65,848,345.4 тн-оор, бодитой (В) нөөцийг 72,265,591.2 тн-оор, боломжтой (С) нөөцийг 52,299,428.5 тн-оор, нийт баттай бодитой боломжтой (А+В+С) нөөцийг 190,413,365.4 тн-оор, уулын цултай нүүрсний баттай (А) нөөцийг 69,010,130.5 тн-оор, бодитой (В) нөөцийг 75,930,632.0 тн-оор, боломжтой (С) нөөцийг 54,983,742.8 тн-оор, нийт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) нөөцийг 199,924,505.3 тн-оор хүлээн авсан.


Хүснэгт 1. Ордын нөөц

Блокийн дугаар	Блокийн талбайн хэмжээ	Нөөц, мян.тонн		
		Өгөршилд орсон	Цэвэр нүүрс	Уулын цултай нүүрс
1A	289,533.4	1,006.13	26,106.65	26,894.18
2A	187,137.4	624.29	16,975.61	17,230.11
3B	240,605.3	969.88	18,259.06	18,880.78
4C	195,712.6	883.59	10,077.03	10,428.24
5B	402,269.8	1,621.55	28,284.39	29,159.73
6A	311,727.6	1,169.91	22,766.09	24,885.84
7B	140,731.9	-	9,531.49	10,660.72
	130,698.6	381.35	-	-
8B	209,331.6	-	11,273.76	12,127.84
	104,665.5	363.71	-	-
9C	236,569.9	-	4,343.42	4,472.12
10C	257,250.9	-	12,175.17	13,294.73
11B	169,735.2	495.46	4,916.89	5,101.56
12C	105,926.8	353.37	5,330.24	5,949.696
13C	124,085.7	-	4,539.13	4,659.03
	73,644.3	405.21	-	-
14C	163,934.4	-	6,438.04	6,553.42
15C	134,930.6	-	9,396.405	9,626.52
Баттай (А) нөөц		**2,800.33**	**65,848.35**	**69,010.13**
Бодитой (В) нөөц		**3,831.95**	**72,265.59**	**75,930.63**
Боломжтой (С) нөөц		**1,642.17**	**52,299.43**	**54,983.74**
НИЙТ ДҮН		**8,274.45**	**190,413.37**	**199,924.5**

1.3. Техник эдийн засгийн үндэслэл

АМГТГ-ийн даргын 2024 оны 6-р сарын 24-ны өдрийн т/87 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2024 оны 5-р сарын 8-ны өдрийн т/24-14-06 тоот дүгнэлт батлагдсан. Төслийн нийт хугацаанд 37,802.8 мян. м3хөрс хуулж, нийт 141,958.0 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэж, 3.0 сая.тн/жилийн хүчин чадалтайгаар 46 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

1.4. Үйл ажиллагааны технологи



Овоолгын төлөвлөлт

Хөрсний гадаад овоолгын төлөвлөлтийг одоогийн ашиглагдаж буй овоолгуудын байршил, нөөцийн блокуудын хил, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, тээвэрлэлтийн зай, чулуулгийн шинж чанар, уурхайн барилга байгууламжийн байршил

зэргийг харгалзан үзэж уурхайн баруун болон хойд хэсэгт 2 гадаад овоолго үүсгэхээр төлөвлөсөн.

Ашиглалтын 19 дэхь жилээс ордын баруун урд хэсгээс эхлэн дотоод овоолго тус тус үүсгэнэ.

1.5. Хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадал 3.0 сая тн/жил нүүрс олборлохоор байна.

1.6. Ажиллах хүчин

Уурхайд нийт 112 ажилтан ажиллах бөгөөд жилд 330 хоног ажиллана.

1.7. Дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж

Уурхайн талбайд ажилчдын ажиллаж, амьдрах бүрэн боломжтой ажилчдын байр, оффис, гал тогоо, ногоон байгууламж, цэвэрлэх байгууламж гэх мэт байгууламжуудыг контейнер, сэндвичин материалаар барьж байгуулсан байна. Харин уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламжид засварын цех, хамгаалалтын албаны байр, сэлбэг материалын агуулах, зоорь, ШТС, гүний худаг, сайжруулсан шороон зам зэргийг багтаасан.

Хүснэгт 2. Барилга байгууламж

№	Хөрөнгийн нэр	Төрөл
1	Ажилчдын байр	Контейнер
2	Оффис	Сендвич
3	Цайны газар	Контейнер
4	Шатахуун түгээх станц	Сендвич
5	Сэлбэгийн агуулах, засварын газар	Сендвич
6	Харуулын байр	Сендвич

Уурхайн оффис



Зураг 2. Уурхайн барилга байгууламж

Уурхайн оффис нь ажилчдын байртай зэрэгцээ байрлах бөгөөд ажилчдад нарьяд өгөх болон сургалт зохион байгуулах заал, инженер техникийн ажилчдын ажлын өрөө, хурлын өрөө, зэргээс бүрдэнэ.

Усан хангамж

Ордын гадаргын болон газар доорх усны судалгаа; Ажлын явцад хайгуулын цооногуудаас 3.8- 30.8 м-ийн гүнд усны ундаргын дээд түвшин тогтоогдсон ба нүүрсний давхраасны ул хүртэл ус алдалт явагдаж байсан. Энэ ус нь зөвхөн доод цэрдийн уст давхаргатай холбоо бүхий хөрсний ус юм. Доод цэрдийн ус агуулагч чулуулаг нь сул барьцалдсан хөрзөн чулуу, гравелит, элсэн чулуу, нүүрс бөгөөд уст давхаргаас ашиглагдаж буй худгуудын ундарга 0.5 л/с хүрнэ.

Орд орчимд байнгын урсдаг гол, горхи талбайн хэмжээнд байхгүй, харин өвөл, зуны аль ч улиралд байнга устай багахан зайд урсаж хөрсөнд шургаж шингэдэг жижиг булгуудтай. Энэ булгуудаас Баянхошуу худаг 20.0 л/цаг, Мөсөн худаг 20.0 л/цаг ундаргатай байдаг. Гидрогеологийн судалгаагаар ордын хэмжээнд 2-3 уст үеүд агуулагдах ба эдгээрийг шаварлаг хурдаснууд тусгаарлана.

Уст үеүд хоорондоо гидравлик холбоотой учир нэг уст цогцолбор үүсгэнэ. Газар доорх ус нь гидравлик шинжээрээ чөлөөт гадаргатай бөгөөд агаарын хур тунадас, тэжээгдлийн мужаас тэжээгддэг. Судалгааны районд ижил настай доод цэрдийн нүүрс агуулсан хурдасны шавхалт туршилтын ажлын үр дүнгээс үзэхэд цооногийн ундарга 2.3-4.0 л/сек, түвшний бууралт 1.1-2.94 м, хувийн ундарга 0.8-3.6 л/сек. Уст давхаргын зузаан дунджаар 6.0 м/хоног, ус дамжуулалтын итгэлцүүр 237-687 м2/хоног, усны түвшин дамжуулалтын итгэлцүүр 2.7х103-4.0х103 м2/хоног байна. /ТЭЗҮ-56-р хуудас/

Ашиглалтын 1 дүгээр жилд хоногт 472.8 м^3, цагт 19.7 м3 ус шавхах, 2-5 дугаар жилд хоногт 703.2 м3, цагт 29.3 м3 ус шавхах, 6-10 дугаар жилд хоногт 467.5 м3, цагт 19.5 м3 ус шавхах тооцоолол гарч байна.

Шатахуун түгээх станц

Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмж, мөн дизель түлшээр ажилладаг бүх тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй ажиллагааг хангах, уурхайн үйл ажиллагааг зогсолтгүй найдвартай байлгахын тулд ШТС-ийг байгуулан ашиглаж байна. ШТС-ийн шатахууны нөөцийг хамгийн багадаа 30 хоногийн нөөцтэй байлгана.


2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

2.1. Байгаль орчны төлөв байдал


Сүхбаатар аймгийн зүүн хэсэгт, Улаанбаатар хотоос 610 км, Дорнод аймгаас 170 км, Аймгийн төвөөс 54 км зайд байрладаг. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Асгат, Халзан, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт сумд, Дорнод аймгийн, Хөлөнбуйр, Булган, Матад сумдтай хиллэдэг. Сүхбаатар сум тал хээрийн бүсэд хамаарах 1,3 сая га талбай бүхий нутаг дэвсгэртэй.

Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Монголын Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын Дундад ухаа гүвээт талын тойрогт багтаж байна.

Төслийн талбайн газрын гадаргын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 964 1087 метрийн хооронд хэлбэлзэж, тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгий 0°-4.2° (градус) байна.



Зураг 3. Төслийн талбайн налуугийн зураглал



Зураг 4. Төслийн талбайн өндөршлийн зураглал

Цаг уурын нөхцөл: Төслийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилд унах хур тунадасны хэмжээ 235.0 мм орчим бөгөөд хур тунадасны ихэнх нь 7, 8, 9-р саруудад ихэвчлэн уулархаг нутгаар унадаг. Дэлхийн дулааралтай холбоотойгоор талбайн хэмжээнд сүүлийн жилүүдэд жилд унах хур тунадасны хэмжээ 30-50 мм-ээр багасаж байгаагийн улмаас орон нутгаар гандуу болж өвс ургамлын гарц эрс муудаж байна.

Жилийн дундаж температур +6.4 0С, хамгийн дулаан нь улирал нь 7, 8-р сард +350С, хамгийн хүйтэн үе нь 1-р сард – 25 0С хүрдэг. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба салхины хурд дунджаар 1-2 м/с байх ба хамгийн их салхи шуургатай улирал нь 5-6 сард болдог. Энэ үед салхины хурд 10 м/с-ээс дээш салхилна. Зарим жилүүдэд тухайлбал 2008 онд байгалийн гамшиг болоход цасан болон шороон шуурга 5-6 хоног үргэлжилсэн ба салхины хурд 25-28 м/с хүрсэн тохиолдол тэмдэглэгдсэн.

Судлагдсан талбай нь Монгол орны зам-уур амьсгалын бүсчлэлээр 2-р бүсэд хамаарах бөгөөд бусад нутаг дэвсгэрийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай.


Хөрсний шинж чанар: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Дэнж нэртэй газар орших “Премиумкөүл корпораци” ХХК-ийн хүрэн нүүрсний орд газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав.

Судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийн онцлог

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Монголын Дорнод мужийн Баруун-Уртын 18-р тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2022).

Хөрсөн бүрхэвч

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн районд тал хөндийн жинхэнэ хүрэн хөрс тархсан байна.



Зураг 5. Төслийн талбайн хөрсний хэв шинж

Хүснэгт 3. Хөрсний зүсэлт

Хөрсний морфологи шинж чанарын бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		SO2
Байршил		Сүхбаатар аймаг Сүхбаатар сум
Координат		46°34'6.37"N 114°13'53.44"E
Өндөр		д.т.д 995.0 метр
Газрын налуу		4.20
Ургамлын бүрхэвч		Алаг өвст бүлгэмдэл
Хөрсний нэр		Жинхэнэ хүрэн хөрс
	Гүн	Морфологи шинж чанар
	0-8 см	Тод хүрэн өнгөтэй, сийрэг, бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэстэй.
	8-40 см	Хүрэн өнгөтэй, сийрэг, өлөн чийгтэй, шилжилт өнгөөр сул.

Ургамал зүйн байдал: Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Төслийн талбайн районд алаг өвс-крыловын хялганат ургамлан бүлгэмдэл тархсан байна. Крыловын хялганат (Stipa Krylovii Roshev) зонхилж, Хос шүдлэг сонгино (Allium bidentatum), Турихан сонгино (Allium tenuissimum L.), Хялгасан дэвхэргийн цагаан (Eremogone capillaris), Ахар навчит хунчир (Astragalus brevifolius), Эгэл цагаан түрүү

(Leontopodium leontopodioides), Өнчин хонгорцогоно (Stemmacantha uniflora (L.) Dittrich) зэрэг ургамлууд дэд зонхилогчоор ургана. Нарийн навчит тарна (Polygonum angustifolium Pall.), Дагуур хатны цэцэг (Cymbaria daurica L.), Ишгүй гичгэнэ (Potentilla acaulis L.), Имт гичгэнэ (Potentilla bifurca L.), Бяцхан навчит харгана (Caragana microphylla Lam.), Нарийн навчит харгана (Caragana stenophylla Pojark.), Саман ерхөг (Agropyron cristatum) Зүүнгарын хазаар өвс (Cleistogenes songorica), Алтайн дааган сүүл (Koeleria altaica), Сунагар биелэг (Poa attenuata Trin.) зэрэг ургана.

Ус зүй: Сүхбаатар аймгийн нутаг бүхэлдээ усан сүлжээний хувьд Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарахын зэрэгцээ гадаргын урсац саринах бүсэд оршдог. Энэ утгаараа тус ай савд багтах гол горхи хэмжээгээрээ бага, усны горимын хувьд тогтворгүй, голцуу хатаж ширгэдэг байна. Тэгэвч эдгээр гол горхи ач холбогдлын хувьд тэр нутагтаа том мөрөн голуудаас бараг дутуугүй байна. Сүхбаатар аймгийн нутгийн хойд хэсгээр Хэрлэн гол эмжээлэн урсах бөгөөд зүүн өмнөд, өмнөд хэсэг Чоногол, Харгилтай, Баян зэрэг гол горхи элбэгийн зэрэгцээ Ганга, Дагшин, Дуут, Өөшийн Цагаан нуурууд мөн Тал булаг, Цавчирын зэрэг рашаантай. Тус аймаг Монголын нийт нуурын 6.1%, талбайн 0.9%-ийг эзлэх 151.4 ам.дөр.км талбайтай 185 тооны нуур бий. Бүх нуур нь улс орны гадаргын дундаж өндрөөс нам түвшинд байрлаж хамгийн өндөр нь 1500 м-ээс үл хэтэрнэ. 10 ам.дөр.км-ээс илүү талбайтай нуур хоёр, талбайн нийлбэр нь 27.2 ам.дөр.км байна. Олонх нуур нь хээр талын бичил хотост тогтож хур бороонь усаар тэжээгдэнэ. Гандуу жилд хатаж шал тойром болдог байна.

3. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ

Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

БОМТ-ний гол зорилго нь уурхайн үйл ажиллагааны хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж эрх бүхий байгууллагаар батлуулах, гүйцэтгэлийг хангуулж хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг тайлангахад оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд 2026 онд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах
- Үйлдвэрийн орчинд ногоон бүс тохижуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авах
- Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх
- БОМТ-ний биелэлт, дүүргийн захиргаатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг орон нутагт тайлагнах зэрэг ажил болно.

БОМТ-ний хамрах хүрээ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 2026 оны БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “Уул уурхай, хүнд үйлдвэрлэл”- ийн төслийн ангилалд хамаарна.

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Премиум көүл корпораци” ХХК нь хүрэн нүүрсний ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт, овоолгоос үүссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно.	Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах	Ил уурхай	$м^3$	УА-ны зардлаар	-	УА-ны зардлаар	2026 он, шаардлагатай өдрүүдэд	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын хавсралт
2		Уурхайн дотоод тээврийн болон гадаад тээврийн замд хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээ байршуулах		Ширхэг	100.0	4	400.0	2026 оны 10-р сард	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр
3	Техник, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах бохирдуулагч орчны агаарыг бохирдуулах	Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийг авто тээврийн улсын үзлэг оношилгоонд оруулах	Уурхайд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, техник	Ширхэг	33.0	10	330.0	2026 онд	“Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам батлах тухай” /2012 оны 12 сарын 31/ Дугаар А/199
4	Агаар орчин бохирдох	Агаар орны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав						МУ-ын Агаарын тухай хуулийн 9.1.3
Нийт зардал			**730.0 мян.төг**						

Хүснэгт 5. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян. Төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усыг заасан хэмжээнээс хэтрүүлж ашиглах	Ус ашиглуулах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулж, гэрээ байгуулан заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн талбай	ҮА-ны зардлаар				2026 онд тогтмол хэрэгжүүлэх	Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Ус ашиглах эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах	Унд ахуйн худгийг хамгаалах, хаалт хашлага хийх	Гүний худаг	Ширхэг	1500.0	1 ш	1500.0	2026 оны 10-р сард	
3	Усны хэрэглээ, ашиглалт ихсэх, усны түвшин буурах	Гүний худагт тавьсан тоолуурыг тогтмол хянах		Дотоод төлөвлөлтөөр					Усны тухай хууль
4	Төслийн талбай орчмын уст цэгийн тоо буурах	Булгийн эхийг хашиж хамгаалах	Төслийн талбай орчмын булаг	Ширхэг	Дотоод төлөвлөлтөөр			2026 оны 10-р сард	Усны тухай хууль
5	Усны бохирдол бий болох	Унд ахуйн болон шүүрлийн усны шинжилгээг хийлгэх	Гүний худаг, уурхайн талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав					Усны тухай хууль,
Нийт зардал				**1500.0 мян.төг**					

Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсөнд шатах тослох материал алдагдах, өнгөн хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх асгаралтын	Төслийн талбай	Ширхэг	500.0	1	500.0	2026 оны 10-р сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/ 8.4.1

		үед ашиглах бэлдэцтэй болох							
2	Төлөвлөгдөөгүй замаар тээвэр хийж олон салаа зам гаргаж өнгөн хөрс доройтуулах	Ашиглалтын талбайд олон салаа зам үүсэхээс сэргийлж тэмдэг тавих, хаалт хийх	Төслийн талбай	Ширхэг	100.0	2	200.0	2026 оны 10-р сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/ 6 дугаар зүйл 6.1.6
3	Ахуйн болон бусад энгийн хог хаягдлаар хөрс бохирдох	Хогийн цэгийг тохижуулах, ангилан ялгах сав байршуулах	Уурхайн түр хогийн цэг	Ширхэг	500.0	1	500.0	2026 оны 10-р сар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Хог хаягдлын тухай” хууль Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019
4	Хөрс бохирдох	Хөрсний мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх	Уурхай орчмын бүс	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав					Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/
Нийт зардал				**1,200.0 мян.төг**					

3.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлт, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн онцлог, Техник эдийн засгийн үнэлгээ, 2026 оны уулын ажлын төлөвлөгөө зэрэгт нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

Хүснэгт 7. Нөхөн сэргээлт, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Арга хэмжээ	Хэмжээ нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төсөл хэрэгжүүлэгч нь Тэрбум мод тарих аяны хүрээнд Сүхбаатар аймгийн	1			2500 (нэг ширхэг хайлаасны суулгацын	5,300.00	2026 онд	MNS 5918:2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын ургамалжуулах.

	Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт 1000 мод тарихаар сум орон нутагтай зөвшилцсөн.		ш	1000	үнэ)+ажлын зардал			Техникийн ерөнхий шаардлага
2	Шимт хөрсийг стандартын дагуу хадгалах хамгаалах	Дотоод төлөвлөлтөөр						MNS 5916 : 2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
	Нийт зардал	**5,300.00**						

3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Зэрлэг амьтдын усны эх үүсвэрийг хамгаалах	Булгийн эхийг хашиж хамгаалах	Төслийн талбай орчим	1	4,500.0	2026 онд	Усны тухай хууль
2	Шувуудын амьдрах орчныг сайжруулах	Шувуудын үүр барих	Төслийн талбай орчим	2	500.0	2026 онд	Амьтны тухай хууль
Нийт зардал					**5,000.0**		

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 1-р багийн нутаг дэвсгэрт орших Баруун манхан булагийн эхийг хашиж хамгаална.

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага,ШУА-ийн Археологийн хүрээлэн болон Сүхбаатар сумын соёлын өвийг хариуцсан мэргэжилтэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож авран хамгаалах арга хэмжээг авна.

3.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Хээрийн түймэр уурхайн талбайд орж ирэх	Хээрийн түймрээс урьдчилан сэргийлж зурвас, далан байгуулах	Уурхайн талбай	Дотоод төлөвлөлтөөр			2026 оны 10-12-р сар	Ой хээрийн түймрээс хамгаалах тухай хууль
2	Шатах тослох материал шатах эрсдэлээс сэргийлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалах, аянга зайлуулагч хийх	Уурхайн ШТС	Дотоод төлөвлөлтөөр			2026 оны 10-р сар	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, түгээх станцын норм ба дүрэм, стандарт
3	Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх, үерийн усанд автах	Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах	Уурхайн талбай	Дотоод төлөвлөлтөөр			2026 оны 9-10-р сар	Гамшгаас хамгаалах тухай хууль
4	Хээрийн түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийх.	Уурхайн ажилчид	1,500.0			2026 он	Ой хээрийн түймрээс хамгаалах тухай хууль
5	Нүүрс өөрөө шатах	Нүүрсний шаталтаас хамгаалах, богино хугацаанд унтраах бэлтгэлтэй байх	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр			2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
Нийт зардал				**1,500.0**				

3.7. Хог хаягдлын менежмент

Хүснэгт 10. Хог хаядлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	**Ахуйн**	Хог хаягдал хадгалах зориулалтын түр хадгалах цэг байгуулж, ангилан	Хог хаягдлын цэгт	ширхэг	300.0	1	300.0	2026 оны 10-12-р саруудад	Хог хаягдлын тухай

		ялгах сав байршуулах, бүрэн бүтэн байдлыг хянах							шинэчилсэн хууль
		Ахуйн хог хаягдлыг зайлуулах талаар Сүхбаатар сумын ЗД-тай гэрээ байгуулж ачуулж, зөөж тээвэрлүүлэх	Уурхайн талбай	удаа	3	3 удаа ачуулах	900.0	2026 оны 10-12-р саруудад	
2	**Аюултай**	Аюултай хог хаягдал аккумлятор, ашигласан тос маслыг цуглуулах түр хадгалах зориулалтын агуулах бүхий хаягдлын цэг бий болгох	Уурхайн талбай	Дотоод төлөвлөлтөөр				2026 онд	
		Аюултай хог хаягдал зайлуулах, устгуулах мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий компанитай гэрээ байгуулах	Уурхайн талбай	Байгууллага хоорондын гэрээгээр				2026 онд	
		Аюултай хаягдал хөрсөнд алдагдахаас хамгаалж түр хадгалах талбайн шалыг хатуу хучилттай болгох, тэмдэгжүүлэх	Аюултай хаягдлын түр хадгалах талбай	Ширхэг	5,000.0	1	5,000.0	2026 онд	
3	**Шингэн**	Төслийн шингэн хог хаягдлыг түр хадгалах савын битүүмжийг хянах, орон нутагтай гэрээ байгуулж зөөвөрлүүлэх	Бага оврын цэвэрлэх байгууламж	Удаа	4	250	1,000.0	2026 оны 9-12-р сард	
Нийт зардал				**7200.0**					

3.8. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 11. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Зардал, мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
1	Хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос	Уурхайн бүс	Жилд 1 удаа	1	120.0	MNS 4585: 2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Кемп		1	120.0	
3		Нүүрс ачилтын талбай		1	120.0	
Усны хяналт шинжилгээ						
3	Унд, ахуйн усны чанарын хими	Гүний худаг	Жилд 1 удаа	1	110.0	

4	Шүүрлийн усны хими	Уурхайн шүүрлийн ус		1	110.0	MNS 0900: 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
Хөрсний хяналт, шинжилгээ						
5	Хөрсний хүнд металлын бохирдол	Ил уурхай	Жилд 1 удаа	1	50.0	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
		Нүүрс ачилтын талбай		1	50.0	
		Уурхайн кемп		1	50.0	
Нийт зардал				**8**	**730.0**	

3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан/ ажилтан	Баримтлах стандарт, арга аргачлал
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	500.0	2026 оны 10-р сард	ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	500.0	2026 оны 10-р сард	ХАБЭА	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3	Нийт ажилчдын эрүүл мэндийн үзлэгт оруулах	ҮА-ны зардлаар	2026 оны 10-р сард	Уурхайн удирдлага	Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах	ҮА-ны зардлаар	2026 оны 10-р сард	ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
5	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	ҮА-ны зардлаар	2026 оны 10-р сард	ХАБЭА	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам Дугаар 75 /2023 оны 11-р сарын 10 өдөр/
6	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	8,000.0	2026 оны 10-р сард	Байгаль орчны ажилтан	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10[1] дүгээр зүйл
	Нийт зардал	**9,000.00**			

3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 13. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан ажиллах байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Нөлөөллийн бүсийн иргэдийг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг танилцуулах	Бичгэн болон илтгэл хэлбэрээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	2026 оны 11-р сард багтааж	300.0	Байгаль орчны мэргэжилтэн болон компаний гүйцэтгэх захирал	Сүхбаатар сумын
3	БОУАӨЯ, Сүхбаатар аймгийн БО-ны газар, ажлын хэсэг	Бичгэн болон илтгэл хэлбэрээр		10-р сарын 30-наас өмнө	200.0	Байгаль орчны мэргэжилтэн	Сүхбаатар аймгийн байгаль орчны газар
Нийт					**500.0 мян.төг**		

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	2026 онд	3,430,000.0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлт, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд хийгдэх ажлын зардал	Төгрөг		5,300,000.0
3	Дүйцүүлэн хамгааллын зардал	төгрөг		5,000,000.0
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг		-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг		1,500,000.0
6	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	төгрөг		9,000,000.0
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төгрөг		7,200,000.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төгрөг		730,000.0
10	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын зардал			500,000.0
НИЙТ ДҮН			**32,660,000.00 төгрөг**	